

Монголын хөдөөгийн ядуурал

Б. Энхцэцэг

МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвийн магистрант

Агуулга

Монгол орон дэлхийд хүн ам хамгийн сийрэг оршин суудаг улсын нэг бөгөөд 1.6 сая кв.км нутагтай, 2.3 сая хүн амтай. Хүн амын бараг тал хувь нь орон нутагт амьдардаг бөгөөд хөдөөгийн хүн амын тал нь нүүдэлчин малчид юм. Монголын эх газрын эрс тэс уур амьсгал, газар зүйн хувьд ихээхэн тархай бутархай байдал хүн амд үндсэн үйлчилгээг хүргэх асуудлыг туйлын хүнд зорилт болгодог.

Монгол улс засаг захиргааны үндсэн нэгжийн хувьд нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт хуваагддаг. Аймгууд нь нийт 342 сумтай тэдгээр нь цаашлан 6-9 баг болж задардаг. Хөдөө орон нутагт хүн ам сийрэг, тархай байршилтай.

1990 оноос Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт эрс өөрчлөлт явагдаж байна. Монгол улсын зах зээлийн харилцаанд шилжих үйл явц эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдалд үүссэн тааламжгүй өөрчлөлтийн үед явагдаж байгаагаас үүдэн хямрал бэрхшээл тулгарч байна. Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц хүн амын амьжиргааны дундаж түвшингийн эрс бууралт түүнээс ч түргэн тэлэн өргөжиж буй ядууралтай зэрэгцэн урагшилж байна.

Иймд ядуурлыг багасгах улмаар арилгах явдал энэ тэргүүнд тавигдаж байна. Орлого багатай бусад улс оронд түүний дотор зах зээлийн харилцаанд шилжиж буй орнуудад хөдөө орон нутагт ядуурал их байдаг. 1995 онд явуулсан амьжиргааны түвшинг тооцох судалгаа(АТХС)-наас харахад Монголын төв сууринд хүн амын 38% ядуу, харин хөдөө орон нутагт 33% ядуу байна. Ядуурал хот, суурин газартаа илүү байна. Тэнд анхаарлыг төвлөрүүлэх ёстой гэж хөрөнгө мөнгийг хүн ам олон суурьшсан нийслэл рүү хувиарлаад байвал монголын хөдөө эзгүйрнэ. Төв рүү чиглэсэн их нүүдэл үүсч, давхар давхар ачаалал нэмэгдэж бэрхшээлтэй зүйл улам ихэснэ.

Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад хөдөөгийн эдийн засаг, түүний дотор МАА-н салбар зонхилох үүрэг гүйцэтгэх юм. Манай улсын эдийн засаг, нийгмийн амьдралд МАА-н үйлдвэрлэл нь урьдын адил зонхилох байр суурийг эзэлсэн хэвээр байна. Аж ахуй эрхлэх, зохион байгуулалтын зарим уламжлалт арга барил өнөөг хүртэл үе дамжин хадгалагдсаар ирэв. 1990 онд хуучин тогтолцоог халж эхлэхэд нэгдэл, Сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйнууд нь өмчийн олон хэлбэрт шилжсэний зэрэгцээ зарим уламжлалт аж ахуйн нэгж, ажлын арга барил сэргэсэн. Гэвч шилжилтийн энэ эгзэгтэй үед хүмүүсийн амьжиргааны түвшин буурах, нийгмийн баталгаа алдагдах явдал хөдөө орон нутгийг тойрсонгүй.

Монголын хөдөө дэх ядуурлын шалтгаан

Монголын хөдөөд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлт нь шинэ боломж бололцоо олгосны зэрэгцээгээр зарим хүндрэл бэрхшээл бий болгож байна. Хөдөө аж ахуйн нэгдлүүд задарсантай холбогдон үйлдвэрлэл, зах зээл, нийгмийн халамжийн үйлчилгээг эрхлэн явуулах газар, нэгж үгүй болсон. Хувийн хэвшлийн аж ахуй, нэгжүүд бий болж үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч одоогоор сул дорой байна. Хувьчлалын үеэр зарим нь чадаагүй байхад зарим малчид ихээхэн ашиг олж хөдөөд баян ядуугийн ялгаа бий болсон.

Мал, өргөн хэрэглээний барааны зах зээлийн борлуулалт багасч, үйлчилгээ ихээхэн буурсан. Хөдөөд ядуурал сүүлийн хагас зуунд үзэгдээгүй өндөр түвшинд хүрч нэмэгдсэн. Хэдийгээр эдийн засгийн зарим нааштай хандлага байлаа ч МАА-н салбарын үр өгөөж болон борлуулалт буурч, малчин өрх гэрийн аж байдал хэдэн 10 жил тогтмол байсан хэмжээнээсээ доошиллоо.

Зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг дагалдан хөдөөгийн олон тооны янз бүрийн байгууллагууд үүссэн бөгөөд хуучнаас уламжлалт цөөн хэд нь үлджээ. 1990 оноос өмнө 40 жилийн турш хөдөө орон нутаг нэгдэл, САА гэдэг нэг цул зохион байгуулалтад оршиж байсан. Төрийн хуучин аппарат 1990 онд задран унахад нэгдлүүд зохион байгуулалтын хэлбэрт маш хурдан хувирсан бөгөөд зарим уламжлалт байгууллагууд дахин сэргэн гарч ирсэн. Нэгдлүүдийг 1991 оноос тарааж мал, машин техник, малын өвлийн хашаа зэрэг хөрөнгийг нь гишүүдэд аажмаар тарааж өгсөн. Энэхүү ажлыг чухам яаж хийхээ нэгдлүүд өөрсдөө шийдэж үүний үр дүнд байгууллагын болон эд хөрөнгийн өмчлөлийн олон төрлийн завсрын хэлбэр бий болсон. Эхэндээ ихэнх нэгдлүүд зарим хөрөнгийг хамтран өмчилж, тойргийн түвшинд аж ахуйгаа нэгдэн төлөвлөсөн компаниуд болж зохион байгуулагдсан. Эдгээр компаниуд нь цаашдаа задарч бүрэн бус хариуцлагатай компаниуд, сайн дурын хоршоо болж эсвэл бүр алга болж айл өрхүүд нь биеэ даасан ардын аж ахуйтан болсон. Хувьчлагдсан нэлээд аж ахуйн нэгжүүд түүхий эд материалын үнийн өсөлт өндөр, олдоц ховор, тээврийн зардал өссөн зэрэг шалтгаанаар удаан хугацаагаар ажиллаж чадахгүй байна. Хөдөө орон нутагт дэд бүтэц, зах зээл хөгжөөгүй, уламжлалт МАА-н ашиг шим бага зэргээс малгүй буюу цөөн малтай иргэд ядууралд орж байна. Мөн эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд байгаль цаг уурын гэнэтийн бэрхшээлээс малчид амьжиргааны гол эх үүсвэр болох малаасаа салж, ядуурах нэг нөхцөл болж байна. Хөдөөгийн ядууралд нийгмийн үйлчилгээний хомсдол илүү нөлөөлж байна. Малчид хувийн өмчтэй болсноор ажиллах хүч дутагдаж хүүхдээ сургуулиас завсардуулан МАА дээр ажиллуулах үзэгдэл гарах болсон. Хөдөө нутгийнхан малжиж, өөрийн гэсэн өмч, үр хүүхдэдээ өвлүүлэх хөрөнгөтэй болж байгаа хэдий ч эмнэлэг, соёлын үйлчилгээ, мэдээллээр гачигдах нь нэлээд хэмжээтэй байгаа юм.

Малын зах зээлийг чөлөөлүүлэхийг гол төлөв байгууллагуудын зохион байгуулалтыг өөрчлөх болон хагас хувьчлал хийж, хувийн худалдааг хууль ёсоор зөвшөөрөх замаар хийсэн. Худалдааны нөхцөл МАА-н үйлдвэрлэгчдэд ашиггүйгээр өөрчлөгдсөн. МАА-н үйлдвэрлэгчдэд

тулгараад байгаа зах зээл, борлуулалтын нөхцөл байдал ноцтой доройтсон. Амьд мал, мах гэсэн тэдний бүтээгдэхүүний үнэ зогсонги байдалд орсон. Гэтэл тэдний хэрэглэдэг үндсэн нэрийн хүнсний зүйлийн үнэ эрс өссөн. Зах зээлд борлуулсан малын тоо бодитойгоор буурч байна.

Эдгээрээс харахад:

- Хөдөө аж ахуйд зах зээлийн шинэ тогтолцоо бүрэлдэж бий болоогүй.
- Мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлт борлуулалтын нөхцлүүд малчдын ашиг сонирхолд тэр бүр нийцэхгүй.
- Малчид, тариаланчид бараа материал, бэлэн мөнгөөр байнгын гачигдалд байгаа
- Гэнэтийн аюулаас сэргийлэх, түүнтэй тэмцэх тогтолцоо байхгүй
- ХАА-н үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, малын тэжээл, эмнэлгийн тусламжийг баталгаажуулах ажил сүүлийн үед дорвитой хийгдэхээ больсон зэргээс үүдэн хөдөөгийн ядуурлын асуудал урьд урьдаас хурц тавигдах болсон.

Хөдөөгийн ядуурлын хэмжих

Хөдөөгийн ядуурлын хэмжээний асуудал маргаантай юм. Зарим хүмүүс "Хөдөөд хүмүүс малтай учир түүгээрээ амьдардаг. Тиймээс ядуурал байхгүй" гэж үздэг. Гэтэл хөдөөд өрх гэр тун цөөн малтай, эмэгтэйчүүд болон хөгшчүүд толгойлсон өрх гэрүүд хөдөлмөр, хөрөнгө нөөц хоёрыг хооронд нь тэнцүүлж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Ядуурал гэдгийг олон янзаар тодорхойлсон байдаг. Товчхоноор ядуурал гэдгийг бага орлого, бага хэрэглээ гэж ойлгож болно. Ядуурлын түшинг тодорхойлохдоо орлого, хэрэглээг гол үзүүлэлт болгож байна. Ядуурлыг орлогоор хэмжихийг ерөнхийдөө хот газар хэрэглэдэг тул олонхи өрх гэр үйлдвэрлэснээ өөрөө хэрэглэдэг хөдөөгийн эдийн засагт уг хэмжүүрийг хэрэглэх нь түвэгтэй юм. Манайд одоо ядуурлын хэмжээг тогтоохдоо ядуурлын шугамыг ашиглаж байна. Ядуурлын шугам гэдэг нь Засгийн газраас тогтоож өгсөн амьжиргааны түвшин юм. Нэг хүнд ногдох орлого амьжиргааны түвшнээс доогуур орсон үед ядуурал яригдана. Ядуурлыг ийнхүү орлогыг үндэс болгон тогтоохдоо хот, хөдөөд ялгаатай авч үздэг. Хотод болон хөдөөд амьдрагсад нь өдөр тутам хэрэглэж байгаа хоол хүнс, орон сууц, түлш шатахуун, гутал хувцас зэрэг хэрэглээний барааны сагсны бүтцээр ялгаатай учраас амьжиргааны баталгаажих доод түвшин ялгаатай байна.

Монгол Улсын Засгийн газар 1992 оноос эхлэн иргэдийн амьжиргааны баталгаажих доод түвшинг хот, хөдөд ялгавартайгаар тогтоон баталж, түүнийг үнэ тарифийн өөрчлөлт, инфляцийн түвшинг харгалзан хагас жил тутам шинэчлэн мөрдүүлж байгаа юм.

Одоо амьжиргааны баталгаажих доод түвшин нийслэлд 10400, Дархан-Уул, Орхон аймагт 10380, өрнөд бүс (Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймаг)-д 9720, дунд бүс (Булган, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг)-д 9420, Дорнод бүс (Дорнод, Хэнтий,

Сүхбаатар аймаг)-д 9250, төвийн бүс (Төв, Сэлэнгэ аймаг)-д 9000 төгрөг байна.

Монголын хөдөөгийн ядуурлын төлөв байдал

Хэдийгээр Монголд ядуу хүмүүс газар сайгүй амьдарч байгаа ч хот сууринд, хөдөө орон нутагт ч мөн дунд хэмжээний хот сууринд (аймгийн төвд) ядуурлын түвшин өндөр байгаа бөгөөд хүмүүс ядуурах тохиолдол их гарч байна. Зарим эх сурвалжаас үзвэл (УСГ 1994, 1995, 1996 он Ядуу өрхийн тайлан) зарим аймагт бусдыг бодвол ядуу зүдүү байдал их гарч байна. 1000 өрхөд ногдох ядуу өрхийн тоогоор Дорноговь, Орхон-Уул, Дундговь, Өмнөговь аймгууд улсын дунджаас доогуур байхад Баянхонгор, Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай аймгууд нэлээд их байна.

Энд тэмдэглэн хэлэхэд хот сууринд бүх аймгийн төв, Улаанбаатар ордог. Хөдөөд сумын төв болон хөдөө орон нутгийг багтааж байгаа юм. Иймд хөдөөгийн ядуурлыг зөвхөн дээрх ангиллаар авч үзэж байгаа болно.

Шилжилтийн энэ үед монголын хүн амын бодит орлого сүүлийн жилүүдэд огцом буурч байна. Эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо, тээвэр болон өргөн хэрэглээний бараа түүний дотроос хүнсний бүтээгдэхүүний хангамж зэрэг нийгмийн үйлчилгээ сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт ихээхэн доголдож байна. Хөдөөгийн олон сургууль хаагдлаа. Сургууль завсардаж байгаа хүүхдийн ихэнх нь хөдөөнийх байна. Эхчүүд, ялангуяа хөдөөний эхчүүдийн эндэгдэл өсч байна. Эхийн эндэгдэл манайд дорвитой буурахгүй байгаа бөгөөд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд жирэмслэлттэй холбоотой эндсэн эхийн үзүүлэлт (100000 амьд төрөлтөд 120-220) өндөр хэвээр байгаа юм. Ялангуяа эндсэн эхчүүдийн ихэнх нь (70 хувь) сумын эмнэлэгт эсвэл хөдөө гэртээ эндэх болов.

Ядуурлын тухай үнэлгээ, шинжилгээ хийхийн өмнө ядуучуудын хөдөлмөр эрхлэлт, эдгээр өрхийн орлогын бүтцийн талаар мэдээ хэрэгтэй юм. Ажилтай хүмүүстэй харьцуулахад ажилгүйчүүд нь гол төлөв залуучууд байх бөгөөд олон хүүхэдтэй гэр бүлд амьдардаг мөн өрхийн гишүүд нь ажилгүй юм уу ажил эрхэлдэг цөөн тооны хүнтэй айл өрхүүд байна. Ажил эрхэлдэг хүмүүстэй харьцуулахад ажилгүйчүүд ихэнхдээ боловсрол багатай байдаг ба ялангуяа дээд боловсрол эзэмшээгүй байх нь олонтой ажиглагдаж байна.

Өрхийн аж ахуйн судалгаа болон статистикийн бусад тайлан мэдээнээс үзэхэд хүн амын амьжиргааны түвшин нь өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн ажил эрхлэлтийн байдалтай шууд хамааралтай байдаг. Өрхийн ам бүл, тэдгээрээс ажил хөдөлмөр хийж орлого олдог хүний тоо өөрөөр хэлбэл, нэг тэжээгчид ногдох тэжээлгэгчийн тооноос тухайн өрхийн амьжиргааны түвшин ямар байх нь шууд хамаардаг. Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан нийт өрхүүдийн дундаж ам бүл хотод 4.7, хөдөөд 4.9 хүн байхад ядуу өрхийн ам бүл хотод 5.5, хөдөөд 6.2 байна.

Хөдөөгийн өрхүүдийн орлогын эх үүсвэр нь мал, ХАА-н бүтээгдэхүүний борлуулалтын болон арилжаа наймааны орлогоос бүрдэж байгаа ерөнхий зүй тогтол ажиглагдаж байна. Зарлагын тухайд монголын хүн ам хүнсэндээ мах, гурилан бүтээгдэхүүн голлон хэрэглэж байгаагийн

дотор ядуучуудад мах, гурилаас өөр төрөл бүрийн амин дэмтэй хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ маш дутмаг байна.

Өрхийн аж ахуйн судалгаанаас харахад хөдөө орон нутагт айл өрхийн зардал (хэрэглээний зардал өндөр) их байгаа нь тэд илүү сайн амьдарч байна гэсэн үг биш юм. Үнэ хэрэг дээрээ энэ нь хотынхныг бодвол хөдөөд айл өрх уг бараа, үйлчилгээний зах зээлийн үнэд арай илүү дөхүү (бодит үнийг) үнийг төлж байна гэсэн үг юм.

Хөдөө орон нутагт амьдарч байгаа ядуучуудын 80 хувь нь цөөн тооны малтай малчид байгаа ба ядуу хүмүүс янз бүрийн салбарт хөдөлмөр эрхэлж байна. Цөөн толгой малтай малчдыг эмзэг бүлэгт хамааруулж байгаа билээ. Амьжиргааны түвшинг хэмжих судалгаа (АТХС)-д хийсэн тооцоогоор хөдөө орон нутагт дунджаар 4 үхэр/адуу, 23 хонь/ямаа буюу барагцаалбал 29 малтай айл өрхийг нэн ядуу гэж үзжээ. Гэтэл чинээлэгдүү малчдын нэг өрх дунджаар 54 толгой малтай байна. Мөн ядуурах шалтгаан нь цөөн тооны малтайгаас гадна айл өрхүүдийн дунд малын тоо толгой тэгш бус хувиарлагдаж байгаагаас болж байна. Ядуу өрхүүд амьдрахын тулд малаа зарах буюу өөрсдөө хэргэлэдгээс энэхүү тэнцвэргүй байдал улам лавширсаар байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд нь Монголын эмзэг бүлгийн нэг юм. Амьжиргааны түвшинг хэмжих судалгаанаас үзвэл хот сууринд өрхийн тэргүүлэгч эмэгтэйчүүдийн гэр бүлийн 63 хувь нь ядуурлын шугамаас доогуур (эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 31%-тай харьцуулахад) амьдарч байгаа ба хөдөө орон нутагт 51 хувийг эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дунд ядуурлын түвшин өндөр байгаа нь хүйсийн ялгаанаас нэг их хамааралгүй бөгөөд харин хүн амын бүтэц хөдөлмөр эрхлэлтийн байдал, нийт айл өрхийн хүний хүчний хөгжлөөс хамааралтай юм. Эрэгтэйчүүд толгойлсон өрхтэй харьцуулвал өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй гэр бүлд ажилтай хүн цөөн, ажилгүй хүмүүс олон байдаг байна. Эрэгтэйчүүд тэргүүлсэн өрхтэй харьцуулахад эмэгтэйчүүдийнх нь боловсролын түвшин багатай байна.

Амьжиргааны түвшинг хэмжих судалгаа (АТХС)-наас үзэхэд хөдөө орон нутаг дахь ядуурлын түвшин өсөж, тухайлбал одоогийн түвшнээс 25%-р нэмэгдэж, хот суурины түвшнээс давах хандлага ажиглагдаж байна.

Эдгээрээс дүгнэхэд шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн хямрал бэрхшээлтэй уялдаад хөдөө орон нутагт ядуурал нэмэгдсээр байгаа бөгөөд энэ нь олон ноцтой сөрөг үр дагавартай байна. Ийнхүү хөдөөгийн ядуурлын асуудал урьд урьдаас хурц тавигдах боллоо.

Иймд ядуурал бий болох үндсийг арилгах, ядуурлаас гарах оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан ажиллаж байна. Уг хөтөлбөрийн үйл ажиллагаа 4 сантай бөгөөд түүний нэг нь орон нутгийн хөгжлийг дэмжих сан юм.

Хөдөөгийн ядуучуудын асуудлыг шийдвэрлэхийн тулд нэгд, эрүүл мэнд (эмчилгээ) болон бусад үйлчилгээ, дэд бүтэц, эцэст нь зах зээлийг

хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хоёрт, хамгийн ядуу өрхийг дэмжиж туслах бодлого хэрэгтэй байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа явуулах чиглэлтэй жижиг үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх нь ажлын байр бий болгох бас нэг арга зам бөгөөд нөөц ч их юм. Малчид болон хөдөөний айл өрхүүд өөрсдийн боломжиндоо тулгуурлан худалдаа үйлдвэрлэл явуулах бүрэн бололцоотой юм. Одоогийн байдлаар малын гаралтай бүтээгдэхүүн (ноос, арьс, мах гэх мэт)-ий ихэнхийг Улаанбаатарт боловсруулж байгаа бөгөөд Дархан-Уул, Дорнод аймгуудад мөн мах комбинат ажиллаж байна. Төвлөрсөн хангамж, төвлөрсөн төлөвлөлт задарч байгаагаас болоод газар тариалан, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах хэрэгцээ шаардлага ихсэж байна. Монголын хувьд мал аж ахуйн салбар нэлээн хүчин чадалтай, хөгжүүлэн сэргээвэл тэргүүлэх салбар байж болох юм. Тус салбарын зохион байгуулалтыг журамлан тогтворжуулж, чөлөөтэй экспортлохыг зөвшөөрч, худалдааны нөхцлийг сайжруулж, хөрөнгө оруулахад зориулж хөдөө орон нутагт бага ч гэсэн хөрөнгө хувиарлах ба малчдын мал хөрөнгийг үндэслэн санхүүжүүлэх ажлыг зохион байгуулж чадсан нөхцөлд мал аж ахуйн салбарын хөгжилд тулгуурлан хөдөөгийн эдийн засаг бүхэлдээ өндийж, орлого, бүтээгдэхүүн хуримтлал нь нэмэгдэж ядуурал буурах болно.

Ашигласан материал:

1. "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр" 1995 он
2. Ядуу өрх, ам бүлийн тайлан 1994, 1995, 1996 он УСГ
3. Дэд. док Дэд порф. Б. Сувд
"Монгол дахь ядуурлын шалтгаан"
4. Өрхийн төсвийн судалгаа 1995 он УСГ
5. "Монгол дахь ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих үе"
Кейт Гриффин тэргүүтэй НҮБХХ-ийн
мэргэжилтний хэсгээс Монголын засгийн газарт
бэлтгэсэн илтгэл 1994 он
6. Шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ
Дэлхийн Банкны баримт бичиг 1995 он